



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар A/13


Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал,
амралтын газрын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай өлгосугай.
2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Мөнх орд ХХК-ийн “Секрет гардэн” зочид буудлын 18/29, Рич холдинг ХХК-ийн “Рич” зочид буудлын 18/69, БХХ трейд ХХК-ийн “Санрайс” зочид буудлын 18/39, Голден лайт хоспиталити ХХК-ийн “Стрийт 63” зочид буудлын 18/73, Буянт их буурал ХХК-ийн “Буянт” зочид буудлын 18/11, Ээвжномт ХХК-ийн “Бамбино” зочид буудлын 17/266, Мазаалай трейд ХХК-ийн “Хавана” зочид буудлын 18/13, Ти зүүм ХХК-ийн “Жое” дэн буудлын 18/78, Нямтөгс ХХК-ийн “Гурван төгс” дэн буудлын 18/18 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.
6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 02
сарын 19 өдрийн А/13 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5234025 СБТ 48926 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.02.19

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх орд ХХК	2047314	Секрет гарден	БГД-ийн, 19-р хороо, 4-р хороолол, Дандинбазарын гудамж, 89-1 тоот
2	Рич холдинг ХХК	5621828	Рич	БГД-ийн, 22-р хороо, Зүүн Нарангийн 18-49 тоот
3	БХХ трейд ХХК	2114399	Санрайс	СБД-ийн, 3-р хороо, Нарны зам 29
4	Голден лайт хоспиталити ХХК	2672715	Стрийт 63	БЗД-ийн, 6-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 63 тоот
5	Буянт их буурал ХХК	5435157	Буянт	БЗД-ийн, 10-р хороо, Улаанхуаран 1/11-191 тоот
6	Ээвжномт ХХК	5043336	Бамбино	БЗД-ийн, 4-р хороо, Б.Доржийн гудамж 38 тоот
7	Мазаалай трейд ХХК	2024543	Хавана	БГД-ийн, 2-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 43 тоот
8	Хонгорын чулгуу ХХК	3186849	Тижи эс	БГД-ийн, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 18 тоот

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 02
сарын 19 өдрийн А/13 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5201025 СБТ 48926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.02.19

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ти зүүм ХХК	5916185	Жое	СБД-ийн, 3-р хороо, Н3-13-29 тоот
2	Нямтөгс ХХК	2615789	Гурван төгс	БГД-ийн, 22-р хороо, 18-р гудамж 71

-ооОо-